

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/06-НА-СТА-ТШЗ

| | |
|---|--|
| Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа |
| | Утас:7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn |
| | Аудитын менежер: Б.Батмөнх |
| | Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn |
| | Аудитор: Ц.Ундраа |
| | Утас: 7036-2442 Цахим хаяг: undraats@audit.gov.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|---|-------|
| 1. Аудитын дүгнэлт:..... | 3-4 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл:..... | 5-11 |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга :..... | 12-14 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа:..... | 12 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин:..... | 12 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал:..... | 13 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт:..... | 13 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв:..... | 14 |
| 4. Аудитын тайлан:..... | 16-17 |
| 4.1 Ерөнхий зүйл:..... | 16 |
| 4.2 Материаллаг байдал:..... | 16 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт:..... | 17 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:..... | 18 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:..... | 18 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал:..... | 18 |
| 5. Аудитын илрүүлэлт:..... | 18 |
| 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:..... | 19-20 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ШЕЗ | Шүүхийн ерөнхий зөвлөл |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМ
ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
О.ХИШИГСҮРЭН ТАНАА

᠒᠐᠒᠔.᠗.᠒᠒ № СЭА-᠒᠐᠒᠔/᠐᠖-НН-СЭА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосноос голлон шалтгаалж тус газрын 2023 оны нийт зардал өмнөх оноос 29.8 хувиар нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Шүүхээр үйлчлүүлж буй иргэдэд мэдээлэл түгээх, шүүхийн үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд мэдээллийн самбарыг шинээр байршуулан, шүүхэд хандаж нэхэмжлэл, хүсэлт гаргах зааврыг QR код уншуулж, хялбар авах боломжийг

бүрдүүлэн, үйлчилгээний шат дамжлагыг багасгаж, түргэн шуурхай, нээлттэй ажиллах боломж бүрдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 5 зорилтын хүрээнд 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 77.2 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | /төгрөгөөр/ |
|------------|--|----------------|-----------------|
| | | | Эцсийн үлдэгдэл |
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 12,738,309.35 | 11,985,519.35 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 1,000,000.00 | 2,200,000.00 |
| 312 | Банк-нд байгаа бэлэн мөнгө | 1,000,000.00 | 2,200,000.00 |
| 3121 | Төгрөг | 1,000,000.00 | 2,200,000.00 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 1,000,000.00 | 2,200,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 11,738,309.35 | 9,785,519.35 |
| 354 | Хангамжийн материал | 11,738,309.35 | 9,785,519.35 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,454,235.35 | 1,981,845.35 |
| 35420 | Аж ахуйн материал | 6,152,049.00 | 6,671,649.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,132,025.00 | 1,132,025.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 688,844,544.45 | 714,776,626.87 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 688,844,544.45 | 714,776,626.87 |
| 392 | Биет хөрөнгө | 678,264,149.98 | 704,390,677.00 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 580,436,315.00 | 580,436,315.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -19,770,255.02 | -33,899,378.90 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 90,000,000.00 | 76,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -42,638,888.87 | -26,527,777.75 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 95,739,144.40 | 92,787,249.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -69,112,432.98 | -37,055,828.78 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 51,051,819.00 | 58,541,819.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -39,036,245.83 | -44,132,255.61 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 38,910,840.00 | 48,310,840.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -8,262,477.72 | -11,016,636.96 |
| 39217 | Ном | 946,332.00 | 946,332.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 10,580,394.47 | 10,385,949.87 |
| 39301 | Программ хангамж | 1,025,000.00 | 1,025,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -736,805.53 | -931,250.13 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 701,582,853.80 | 726,762,146.22 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 701,582,853.80 | 726,762,146.22 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 701,582,853.80 | 726,762,146.22 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 155,648,199.00 | 155,648,199.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 155,648,199.00 | 155,648,199.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 290,683,596.55 | 315,862,888.97 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 290,683,596.55 | 290,683,596.55 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 25,179,292.42 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 255,251,058.25 | 255,251,058.25 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 701,582,853.80 | 726,762,146.22 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|---------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 888,027,465.00 | 1,029,215,310.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 197,470,765.00 | 58,248,910.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 197,470,765.00 | 58,248,910.00 |
| 120009 | Бусад орлого | - | 47,000,000.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан -Үндсэн хөрөнгө | | 8,935,610.00 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материал | | 2,313,300.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 690,556,700.00 | 970,966,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 690,556,700.00 | 970,966,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 690,556,700.00 | 970,966,400.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 737,108,267.83 | 1,004,036,017.58 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 737,108,267.83 | 1,004,036,017.58 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 673,742,717.83 | 885,682,893.80 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 484,048,017.00 | 657,840,461.00 |
| 210101 | Үндсэн цалин | 334,979,125.00 | 430,586,485.00 |
| 210102 | Нэмэгдэл | 112,113,072.00 | 148,344,591.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,317,031.00 | 20,658,000.00 |
| 210104 | Урамшуулал | 23,638,789.00 | 58,251,385.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 60,404,951.00 | 82,915,461.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,253,049.00 | 56,382,506.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,816,146.00 | 6,633,236.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,852,875.00 | 5,306,589.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 953,031.00 | 1,326,647.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,529,850.00 | 13,266,483.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 36,775,101.00 | 43,120,668.48 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,196,900.00 | 4,159,773.63 |
| 210302 | Түлш, халаалт | 31,342,851.00 | 37,058,421.85 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,235,350.00 | 1,902,473.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 25,379,115.00 | 32,180,707.74 |
| 210401 | Бичиг хэрэг | 11,246,090.00 | 14,956,940.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,500,000.00 | 6,260,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,174,765.00 | 4,133,957.74 |
| 210404 | Ном, хэвлэл | 600,000.00 | 576,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал | - | 326,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,858,260.00 | 5,927,410.00 |
| 2105 | Норматив зардал | 365,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 365,000.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,247,000.00 | 9,186,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,247,000.00 | 825,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,000,000.00 | 8,361,400.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,421,800.00 | 6,234,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,421,800.00 | 6,234,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,722,396.00 | 6,626,168.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,877,500.00 | 4,781,572.00 |

| | | | |
|--------|---|----------------|----------------|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,737,700.00 | 1,737,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 52,614.00 | 52,614.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 44,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 10,582.00 | 10,282.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 51,379,337.83 | 47,578,527.58 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 51,379,337.83 | 47,578,527.58 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 63,365,550.00 | 118,353,123.78 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 46,647,300.00 | 98,000,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 46,497,300.00 | 97,200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 150,000.00 | 800,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 16,718,250.00 | 20,353,123.78 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,718,250.00 | 20,353,123.78 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 150,919,197.17 | 25,179,292.42 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 150,919,197.17 | 25,179,292.42 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/ |
|------------|--|---------------------|-----------------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 691,556,700.00 | 972,966,400.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,000,000.00 | 2,000,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,000,000.00 | 2,000,000.00 |
| 120009 | Бусад орлого | 1,000,000.00 | 2,000,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 690,556,700.00 | 970,966,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 690,556,700.00 | 970,966,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 690,556,700.00 | 970,966,400.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 689,413,700.00 | 954,191,400.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 689,413,700.00 | 954,191,400.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 626,048,150.00 | 835,838,276.22 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 484,048,017.00 | 659,840,461.00 |
| 210101 | Үндсэн цалин | 334,979,125.00 | 430,586,485.00 |
| 210102 | Нэмэгдэл | 112,113,072.00 | 150,344,591.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,317,031.00 | 20,658,000.00 |
| 210104 | Урамшуулал | 23,638,789.00 | 58,251,385.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 60,404,951.00 | 82,915,461.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,253,049.00 | 56,382,506.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,816,146.00 | 6,633,236.00 |
| 210203 | ҮОМШӨ -ний даатгал | 3,852,875.00 | 5,306,589.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 953,031.00 | 1,326,647.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,529,850.00 | 13,266,483.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 36,775,101.00 | 43,120,668.48 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,196,900.00 | 4,159,773.63 |
| 210302 | Түлш, халаалт | 31,342,851.00 | 37,058,421.85 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,235,350.00 | 1,902,473.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 27,818,885.00 | 27,914,617.74 |
| 210401 | Бичиг хэрэг | 14,389,250.00 | 12,439,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,500,000.00 | 6,260,000.00 |

| | | | |
|--------|--|---------------|----------------|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,174,765.00 | 4,133,957.74 |
| 210404 | Ном, хэвлэл | 600,000.00 | 576,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 326,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,154,870.00 | 4,178,710.00 |
| 2105 | Норматив зардал | 500,000.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 500,000.00 | 00.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,357,000.00 | 9,186,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,357,000.00 | 825,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,000,000.00 | 8,361,400.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,421,800.00 | 6,234,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,421,800.00 | 6,234,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,722,396.00 | 6,626,168.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,877,500.00 | 4,781,572.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,737,700.00 | 1,737,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 52,614.00 | 52,614.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 44,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 10,582.00 | 10,282.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,000,000.00 | 00.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,000,000.00 | 00.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 63,365,550.00 | 118,353,123.78 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 46,647,300.00 | 98,000,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 46,497,300.00 | 97,200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 150,000.00 | 800,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 16,718,250.00 | 20,353,123.78 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,718,250.00 | 20,353,123.78 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 2,143,000.00 | 18,775,000.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 1,143,000.00 | 17,575,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,143,000.00 | 17,575,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 1,143,000.00 | 17,575,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,143,000.00 | 17,575,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -1,143,000.00 | -17,575,000.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 1,000,000.00 | 1,200,000.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 1,000,000.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,000,000.00 | 2,200,000.00 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| C01 | 2022 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл | 155,648,199.00 | 255,251,058.25 | 139,764,399.38 | 550,663,656.63 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 155,648,199.00 | 255,251,058.25 | 139,764,399.38 | 550,663,656.63 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 150,919,197.17 | 150,919,197.17 |
| C08 | 2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 155,648,199.00 | 255,251,058.25 | 290,683,596.55 | 701,582,853.80 |
| D01 | 2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 155,648,199.00 | 255,251,058.25 | 290,683,596.55 | 701,582,853.80 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 155,648,199.00 | 255,251,058.25 | 290,683,596.55 | 701,582,853.80 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 25,179,292.42 | 25,179,292.42 |
| D09 | 2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 155,648,199.00 | 255,251,058.25 | 315,862,888.97 | 726,762,146.22 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--------|--|-----------------------|----------------|-----------------|------|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 971,799,800.00 | 950,613,276.22 | 21,186,523.78 | 97.8 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 971,799,800.00 | 950,613,276.22 | 21,186,523.78 | 97.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 873,599,800.00 | 853,413,276.22 | 20,186,523.78 | 97.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 666,740,500.00 | 659,840,461.00 | 6,900,039.00 | 99.0 |
| 210101 | Үндсэн цалин | 417,643,600.00 | 430,586,485.00 | (12,942,885.00) | 103 |
| 210102 | Нэмэгдэл | 166,018,100.00 | 150,344,591.00 | 15,673,509.00 | 90.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 30,782,300.00 | 20,658,000.00 | 10,124,300.00 | 67.1 |
| 210104 | Урамшуулал | 52,296,500.00 | 58,251,385.00 | (5,954,885.00) | 111 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 82,925,200.00 | 82,915,461.00 | 9,739.00 | 100 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,687,400.00 | 56,382,506.00 | 2,304,894.00 | 96.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,059,400.00 | 6,633,236.00 | (573,836.00) | 109 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,847,600.00 | 5,306,589.00 | (458,989.00) | 109 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,211,900.00 | 1,326,647.00 | (114,747.00) | 109 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,118,900.00 | 13,266,483.00 | (1,147,583.00) | 109 |

| | | | | | |
|--------|--|-----------------------|-----------------------|----------------------|-------------|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 43,757,900.00 | 43,120,668.48 | 637,231.52 | 98.5 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,000,000.00 | 4,159,773.63 | 840,226.37 | 83.2 |
| 210302 | Түлш, халаалт | 37,137,900.00 | 37,058,421.85 | 79,478.15 | 99.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,620,000.00 | 1,902,473.00 | (282,473.00) | 117 |
| 210304 | Байрны түрээс | - | - | - | - |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 32,278,400.00 | 27,914,617.74 | 4,363,782.26 | 86.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 10,569,000.00 | 12,439,550.00 | (1,870,550.00) | 117 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,493,600.00 | 6,260,000.00 | 2,233,600.00 | 73.7 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,115,800.00 | 4,133,957.74 | 2,981,842.26 | 58.1 |
| 210404 | Ном, хэвлэл | 600,000.00 | 576,000.00 | 24,000.00 | 96.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 600,000.00 | 326,400.00 | 273,600.00 | 54.4 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,900,000.00 | 4,178,710.00 | 721,290.00 | 85.3 |
| 2105 | Норматив зардал | 500,000.00 | - | 500,000.00 | 0.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 500,000.00 | - | 500,000.00 | 0.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 26,761,400.00 | 26,761,400.00 | - | 100 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,000,000.00 | 9,000,000.00 | - | 100 |
| 210604 | Урсгал засвар | 17,761,400.00 | 17,761,400.00 | - | 100 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 8,101,800.00 | 6,234,500.00 | 1,867,300.00 | 77.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,101,800.00 | 6,234,500.00 | 1,867,300.00 | 77.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 12,334,600.00 | 6,626,168.00 | 5,708,432.00 | 53.7 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,448,000.00 | 4,781,572.00 | 5,666,428.00 | 45.8 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,737,700.00 | 1,737,700.00 | - | 100 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 71,900.00 | 52,614.00 | 19,286.00 | 73.2 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 44,000.00 | - | 100 |
| 210807 | Газрын төлбөр | 33,000.00 | 10,282.00 | 22,718.00 | 31.2 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 200,000.00 | - | 200,000.00 | 0.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 200,000.00 | - | 200,000.00 | 0.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 98,200,000.00 | 97,200,000.00 | 1,000,000.00 | 99.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 98,200,000.00 | 97,200,000.00 | 1,000,000.00 | 99.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 97,200,000.00 | 97,200,000.00 | - | 100 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | - | 1,000,000.00 | 0.0 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 971,966,400.00 | 950,613,276.22 | 21,353,123.78 | 97.8 |

| | | | | | |
|--------|---|----------------|----------------|---------------|------|
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 971,966,400.00 | 950,613,276.22 | 21,353,123.78 | 97.8 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 971,966,400.00 | 950,613,276.22 | 21,353,123.78 | 97.8 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | - | - |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 22 | 22 | - | 100 |
| 620001 | Удирдах ажилтан | 2 | 2 | - | 100 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 17 | 17 | - | 100 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3 | 3 | - | 100 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 22.0 | 22.0 | | |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9 | 9 | | |
| 650003 | Төрийн тусгай албан хаагч /ТТ/ | 4 | 9 | | |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 9 | 9 | | |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар нь “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүн таслах ажиллагааг хэвийн, тасралтгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, шүүхийн үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй хүргэх” гэсэн эрхэм зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах, шүүхийн хүний нөөц, шүүхийн судалгаа, мэдээлэл, олон нийтийг мэдээллээр хангах зэрэг хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Шүүхийг өдөр тутмын үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлөөр хангах,
- Шүүхийн хөдөлмөр зохион байгуулалт, дотоод журмын биелэлтэд хяналт тавих,
- Шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, бүртгэх,
- Шүүхийн бичиг хэрэг, захидал харилцаа, шуудан, архивын үйл ажиллагааг зохион байгуулах,
- Шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээ авах, хэргийн эд мөрийн баримтыг хадгалах, зөөвөрлөх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Шүүхийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
 - Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
 - Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ШЕЗ-ийн Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албанаас хяналт тавьдаг бөгөөд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар нь ШЕЗ-ийн газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 174 дүгээр тушаалаар баталсан “ШЕЗ-ийн ажлын алба, анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25,179.29 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мянган төгрөгөөр /

| | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|----------|---|-------------------|--------------------|------------------|
| А | Б | 1 | 2 | 3=2-1 |
| 1 | Мөнгөн хөрөнгө | 1,000.00 | 2,200.00 | 1,200.00 |
| 2 | Авлага | | | |
| 3 | Урьдчилж гарсан зардал | | | |
| 4 | Бараа материал | 11,738.30 | 9,785.52 | (1,952.78) |
| 5 | Үндсэн хөрөнгө | 688,844.55 | 714,776.62 | 25,932.07 |
| 6 | Нийт хөрөнгө | 701,582.85 | 726,762.14 | 25,179.29 |
| 7 | Өр төлбөр | | | |
| 8 | Засгийн газрын хувь оролцоо/Эздийн өмч/ | 701,582.85 | 726,762.14 | 25,179.29 |
| 9 | Өр төлбөр ба цэвэр хөрөнгө | 701,582.85 | 726,762.14 | 25,179.29 |


Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл нь 2,200.0 мянган төгрөг болж, 1,200.0 мянган төгрөгөөр өссөн нь ШЕЗ-өөс өгсөн чиглэлийн дагуу цалингийн зардлын хэмнэлтээс 2,000.0 мянган төгрөгийг төрийн сан дахь “Ахмадын сан”-гийн 100130405501 тоот дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 9,785.5 мянган төгрөг болж 1,952.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 32,640.6 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, ШЕЗ-өөс 2,313.3 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, 36,906.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 714,776.6 мянган төгрөг болж 25,932.07 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 17,575.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, 8,935.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилгыг ШЕЗ-ийн даргын 2023 оны 226 дугаар тушаалаар үнэ төлбөргүй хүлээн авч, ТӨБЗГ-ын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 421 дүгээр тогтоолоор 70,836.4 мянган төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг

47,000.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, 73,572.5 мянган төгрөгийн элэгдлээр анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг акталснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 726,762.14 мянган төгрөг болж 25,179.29 мянган төгрөгөөр өссөн нь нийт хөрөнгийн өсөлт, тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.



3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг **964,240.0** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 204,160.0 мянган төгрөгийг бууруулан ШЕЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 23 өдрийн 346 дугаар тогтоолоор 760,080.0 мянган төгрөгийг баталсан байна. Үүнд:

Цалин хөлс НДШ -ын зардал 86,105.9 мянган төгрөгөөр, хангамжийн материалын зардал 2,213.5 мянган төгрөгөөр, тавилга эд хогшил, урсгал засварын зардал 11,855.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 1,285.0 төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардал 102,700.0 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсөвт тодотгол, зохицуулалт хийж 211,719.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүнд:

Цалин хөлс НДШ -ын зардал 87,258.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардал 4,000.0 мянган төгрөгөөр, хангамжийн материалын зардал 2,500.0 мянган төгрөгөөр, тавилга эд хогшил, урсгал засварын зардал 13,761.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 6,000.0 төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардал 98,200.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн **971,799.8** мянган төгрөгийг эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 971,799.8 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр 970,966.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 950,613.3 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 20,353.1 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| дд | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | /Мянган төгрөгөөр/ | |
|----|-------------------------------------|------------------|------------------|--------------------|-----------------|
| | | | | Зөрүү | Биелэлтийн хувь |
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 870,151.8 | 851,835.6 | 18,316.2 | 97.8 |
| 2 | Зөвлөл хороо комиссын гишүүд | 2,000.0 | 1,462.7 | 537.3 | 73.1 |
| 3 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 98,200.0 | 97,200.0 | 1,000.0 | 98.9 |
| 4 | Шинжээч орчуулагч хэлмэрчийн зардал | 1,448.0 | 115.0 | 1,333.0 | 7.9 |
| | Дүн | 971,799.8 | 950,613.3 | 21,186.5 | 97.8 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130905501 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн тухайн жилийн төсвийн төлөвлөгөөнд “Ахмадын сан”-ийн зардлыг тусган, батлуулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Ундраа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 737,108.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,371.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тус байгууллага нь тайлант онд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлж, бичиг хэрэг, шуудан холбооны зардлыг хэмнэсэн,
- Шүүхийн танилцуулга зэрэг тараах материал хэвлэх зардлыг зогсоосон,
- Ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувилал, төрсөн нутагтаа амрах тохиолдолд очих, ирэх замын зардлыг олгоогүй.
- Нормын хувцас, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг хэмнэж шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй. Цахилгааны зардлыг хэмнэхийн тулд өдөр, шөнийн тарифаар бодогддог тоолуур тавиулж төсвийг зохистой хэмнэлттэй удирдаж, авлага, өглөг үүсгэлгүй ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар нь мэдээлбэл зохих 28 төрлийн 159 мэдээллээс 157 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 1 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй байна. Үүнд:


Хугацаа хоцроосон:

- Төсвийн байгууллагын дараа жилийн төсвийн төсөл 9-р сард

Огт мэдээлээгүй:

- 2023 оны шилэн дансны 2 улирлын тайлан

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж өгөв.



4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 123 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар урамшууллыг давхардуулан олгосон болон жилийн эцэст төсвийн хэмнэлтийг татан төвлөрүүлэлгүйгээр бараа материал худалдан авч нөөцөлсөн зэрэг 2 зөвлөмж өгөгдсөн бөгөөд зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|----------|------------------------|---------|---------|---------|------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 2 | 4,558.5 | 2 | 4,558.5 | 100% |
| Нийт дүн | 2 | 4,558.5 | 2 | 4,558.5 | 100% |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,200.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

5.1 Зөвлөмж

1.1 Илрүүлэлт: ШЕЗ-өөс өгсөн чиглэлийн дагуу цалингийн зардлын хэмнэлтээс 2,200.0 мянган төгрөгийг Төрийн сан дахь “Ахмадын сан”-ийн 100130405501 дугаар дансанд төвлөрүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Ахмадын санд шаардагдах хөрөнгийг журамд заасны дагуу ирэх оны төсөвт тусгуулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5¹ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15 - ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|-------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | /мянган төгрөгөөр/ | | | | | | | | | |
|---|-------------|-----|--------------------|-----|-----------------|-----|---------|---------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Ахмадын санд шаардагдах хөрөнгийг төлөвлөөгүй | 1 | | | | | | 1 | 2,200.0 | | | | |
| Дүн | 1 | | | | | | 1 | 2,200.0 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | /мянган төгрөгөөр/ | | | | | |
|--|-------------|-----|--------------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Мэдээллийг хугацаа хоцроож мэд | 1 | | | | | | | 1 |

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

| | | | | | | | | | |
|--|---|--|--|--|--|--|--|---|--|
| Огт мэдээлээгүй | 1 | | | | | | | 1 | |
| Дүн | 2 | | | | | | | 2 | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | | |

Handwritten notes and stamps in Mongolian script, including a red stamp with the number 4317 and the text "МЮА0000".